

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.04.01

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Беренберг Банк Рио Тинто компанийн хувьцаанд өгсөн авах зөвлөмжөө хэвээр үлдээж, ханшийн зорилтыг 74.5 ам.долларт тооцооллоо.
- Тесла компанийн хувьцаанд өгсөн авах зөвлөмжөө Deutsche Bank хэвээр үлдээж зорилтот ханшийг 200 ам.долларт тооцооллоо.
- Ethereum ETF гарах боломжтойг Blackrock хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх захирал Ларри Финк мэдэгдлээ
- Huawei компанийн 2023 оны цэвэр ашиг 50 тэрбум юаниар буюу 2 дахин өслөө.

2024 он 04-р сарын 01

Dow Jones	39,807.37
S&P 500	5,254.35
Nasdaq	16,379.46
DAX	18,504.51
FTSE 100	7,952.62
S&P/ASX 200	7,896.90
HANG SENG	16,541.42

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.12%	1.26%	1.84%	5.62%	19.63%	20.07%
S&P 500	0.11%	0.69%	2.28%	10.16%	27.86%	30.71%
Nasdaq	-0.12%	-0.03%	0.64%	9.11%	34.02%	21.51%

2024 оны 04 сарын 01-ны 15:00



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.15%	1.33%	4.34%	10.46%	18.40%	22.49%
FTSE 100	0.26%	0.44%	3.52%	2.84%	4.20%	18.04%

2024 оны 04 сарын 01-ны 15:00



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.00%	1.09%	1.95%	4.03%	10.02%	15.64%
Hang Seng	0.00%	0.41%	-0.29%	-2.97%	-18.92%	-42.84%

2024 оны 04 сарын 01-ны 15:00





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

АНУ-ын S&P500 индекс эхний улирлын төгсгөлд бүх цаг үеийн түүхэн дээд ханшаа шинэчлэн тогтоож, оны эхний 3 сард нийтдээ 10 хувь өссөн байна. Бусад томоохон индексүүд болох Dow Jones болон NASDAQ100 индексүүд оройн цэгтэйгээ ойрхон арилжаалагдлаа.

Өнгөрсөн пүрэв гарагт Мичиганы их сургуулийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн шалгуур үзүүлэлт сайн гарсан бөгөөд энэ нь инфляцийн айдас буурсантай холбоотойгоор сүүлийн 21 сарын хамгийн дээд түвшинд хүрчээ. 2024 оны эхний гурван сарын хугацаанд эдийн засгийн нөхцөл байдал хэрэглэгчдэд хэвийн байгаа мэт мэдрэгдэж байна гэсэн дүгнэлт гарчээ.

Хөрөнгө оруулагчид инфляц буурч байгаагаас шалтгаалан эдийн засаг хүнд уналтаас зайлсхийж зөөлөн газардах төлөвтэй байна гэсэн итгэлийн хамтаар баасан гарагт зарлагдах ажлын байрны тайланг хүлээж байна.

Өнгөрсөн 2 сард АНУ-д 275,000 ажлын байр нэмэгдсэн бол гуравдугаар сард өмнөх сараас арай бага буюу 205,000 ажлын байраар нэмэгдэнэ хэмээн таамаглаж байна.

3 сард хуралдсан ХНС энэ онд гурван удаа хүүгээ бууруулж, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөвөө сайжруулна гэсэн байр сууриа илэрхийлсэн тул эдийн засаг "зөөлөн газардах" магадлал улам нэмэгдэв.

График 1: S&P500 индекс





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

БНХАУ-ын хувьцаанууд Пүрэв гарагийн байдлаар уналттай хаагдлаа. Shanghai Composite индекс 1.23%-иар унасан бол CSI 300 blue chip 0.68%-иар уналаа. Харин Хонг Конг-д Hang Seng индекс 0.25%-иар өслөө. Үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилсээр байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлд сөргөөр нөлөөлж, Хятадын хувьцаануудын ханш өнгөрсөн долоо хоногт буурсан байна.

Хятадын Ерөнхий сайд Ли Цян жил бүр болдог Хятадын хөгжлийн форумд оролцогчдод хандан тус улс гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй байгааг мэдэгдлээ. Түүнчлэн биологийн үйлдвэрлэл, хиймэл оюун ухаан, мэдээллийн эдийн засаг зэрэг хэд хэдэн салбарын өсөлтийг дэмжих арга хэмжээг эрчимжүүлнэ гэж Ерөнхий сайд Ли Цян амлалаа. Олон улсын валютын сангийн гүйцэтгэх захирал Кристалина Георгиева мөн өдөр хэлэхдээ, Хятад улс зах зээлийг дэмжсэн шинэчлэл хийвэл ирэх 15 жилийн хугацаанд эдийн засаг 20%-иар өсөх боломжтой гэж мэдэгдэлдээ дурджээ.

Үндэсний Статистикийн Товчооны мэдээлснээр аж үйлдвэрийн пүүсүүдийн ашиг өнгөрсөн оны 1-2 дугаар сарын хугацаанд өмнөх оны мөн үеэс 10.2%-иар өсч, бодлогын дэмжлэг болон гадаад дахь эрэлт нэмэгдсэн байна. Хоёр сарын хугацаанд аж үйлдвэрлэл, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт, жижиглэнгийн борлуулалт нэмэгдсэнийг үзэхэд Хятадын эдийн засаг хурдацтай хөгжиж байгааг нотолж байна. Гэсэн хэдий ч дефляцийн дарамт, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт үргэлжилсээр байгаа нь хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлсөөр байна.

График 2: CITIC Securities /HKEX:6030/ компанийн хувьцааны ханш















CITIC Securities үнэт цаасны компани нь БНХАУ-ын хамгийн том үнэт цаасны компани бөгөөд БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн арилжаа идэвхжиж, бондын зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл өсөхтэй зэрэгцэн өсөх хүлээлттэй байна.

ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
March 25, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 BITCOIN DEPOT	 Westport Fuel Systems	 McCormick	 GameStop	 CARNIVAL CORPORATION & PLE	 RH	 Wegmans Food Alliance	 eenergous		
 SYRA	 bakkt	 TD SYNEX	 Direct Digital Holdings	 altimmune	 urban-gro	 HUT 8	 VUZIX		
 SyraHealth	 REKOR	 LUNA	 OUSTER	 CINTAS	 braze	 AZUL	 ZEVRA THERAPEUTICS		
 VIOMI	 Sanara MedTech	 GDS 万国数据	 Progress	 PAYCHEX	 GREE	 CONSOLIDATED WATER	 planet.		
	 the metals company	 BIOLINE	 CONCENTRIX	 gamida Cell	 GREENIDGE GENERATION	 D:WAVE	 OXFORD		
	 GREENTREE HOSPITALITY GROUP	 DOUYU	 ncino	 LANDS' END	 VERINT	 DARE	 darébio		
	 DADA	 BRAGG	 BIORA Therapeutics	 R3E	 FranklinCovey	 GoldRoyalty	 SURFAIR MOBILITY		
	 达达集团	 TERRAN ORBITAL	 Panbela	 edaptrms	 H.B. Fuller	 AT&T	 SEMTECH		
		 Elbit Systems	 INTRUSION	 TEN LTD	 sprinklr	 DARIO	 sharecare		
		 Acumen	 NORTHSTAR GROUP HOLDINGS	 SYRS	 Jefferies	 CNH	 emeran		
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers			

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
April 01, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 NANOX	 PVH	 PAYCHEX	 PLAY	 AcuityBrands	 BlackBerry	 Lamb Weston	 KURA	 byrna	
 SIGMA LITHIUM	 CANOO		 EM	 IceCure	 Levi's	 CONAGRA FOODS		 THE GREENBRIER COMPANIES	
 ONDAS NETWORKS	 microvast			 BiomX	 SimulationsPlus	 Simply Good			
 TERRAN ORBITAL	 PIONEER POWER SOLUTIONS				 SPORTSMAN'S WATERWAYS	 angiodynamics			
 LMFA	 ZOM				 RGP	 LINDSAY			
 LMFUNDING	 ZOMEDICA					 RPM			
 decisionpoint	 OMEROS					 CollPlant			
 JAGX	 duostech					 radius recycling			
 Jaguar Health	 NYC NEW YORK CITY REIT								
 VENUS CONCEPT	 NGS								
 ESCALADE I N C.	 VirTra								
 MNR									
 NATURAL RESOURCES									
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers			